213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	180,000.00	800,000.00	800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,025,000.00	-	2,183,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,025,000.00	-	2,183,000.00
220001	Барилга байгууламж				
221001	Их засвар				
222001	Тоног төхөөрөмж	-	4,025,000.00	-	2,183,000.00
223001	Бусад хөрөнгө				
224001	Стратегийн нөөц хөрөнгө				
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр				
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл				
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл				
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл				
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	385,159,700.00	358,684,840.00	63,644,900.00	55,877,440.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	331,448,700.00	331,447,900.00	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих				
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,448,700.00	331,447,900.00	-	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,211,000.00	21,211,400.00	30,935,500.00	30,935,500.00

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Орон нутгийн төсвөөс	21,211,000.00	21,211,400.00	30,935,500.00	30,935,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	4,451,640.00	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	3,301,140.00	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	1,150,500.00	-	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих				
120004 4	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	32,500,000.00	1,573,900.00	32,709,400.00	24,941,940.00
122001	Хандив тусламж /дотоод/	32,500,000.00	1,573,900.00	32,709,400.00	24,941,940.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	-	-	-
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-	-	-
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	-	-	-
630001	Төрийн өмчит ЕБС				
630002	Хувийн ЕБС				
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	-	-	-	-
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага				
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага				
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	-	-	-	-
632001	Төрийн өмчит МСҮТ				
632002	Хувийн МСҮТ				
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо				
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо				
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	25.00	25.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)				
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)				
650003	Ажлын албаны албан хаагч (АА)				
650004	СЭБ болон бага, дунд				

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	боловсролын албан хаагч (ТҮБД)				
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)				
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)				
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)				
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	15.00	15.00	15.00	15.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00	6.00	6.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)				

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: ЭМТ

Тайлант хугацаа: 2020.12.31

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		13,828,200.00	-13,828,200.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		13,828,200.00	-13,828,200.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,628,200.00	-13,628,200.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил				
2E+05	Үндсэн цалин				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл				
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
2104	Хангамж, бараа материалын зардал		228,200.00	-228,200.00	
2E+05	Тээвэр, шатахуун		228,200.00	-228,200.00	
2105	Нормативт зардал		13,400,000.00	-13,400,000.00	
2E+05	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		13,400,000.00	-13,400,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
2107	Томиллолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		200,000.00	-200,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг		200,000.00	-200,000.00	
2E+05	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		200,000.00	-200,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
	Дотоод эх үүсвэрээр				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		13,828,200.00	-13,828,200.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		13,828,200.00	-13,828,200.00	
1E+05	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,828,200.00	-13,828,200.00	
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

3.Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга М.Соёлмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах,үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Дашинчилэн сумын ЭМТ нь тайлант хугацаанд “Эрүүл иргэн-Ирээдүйн баялаг” гэсэн зорилго дэвшүүлж үүний хүрээнд 4 зорилтыг дэвшүүлж ажиллажээ. Үүнд:

- Дэвшилтэт технологийг нэвтрүүлж нотолгоонд суурилсан аюулгүй чанартай тусламж үйлчилгээг үзүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, нийгмийн баталгааг хангах
- Иргэн бүрийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, зөв дадал хэвшилд сургах
- Зайлшгүй шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах гэсэн зорилтууд тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй, байгууллагын НБББББ-ийг шинэчлэн боловсруулсан байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Дашинчилэн сумын ЭМТ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэн боловсруулжээ.

ХАК нь 2020 онд Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 1536.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 256.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1280.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн хариуг хугацаанд нь ирүүлж ажиллажээ.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж дуусгавар болсон тайланд дурдсан байна.

Мөн ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-д тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 219359.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4387.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон төлөвлөж, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 476142.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9522.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21331.9 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	47956.6	35750.8	-12205.8
Үндсэн хөрөнгө	272569.5	306107.3	33537.8
Нийт хөрөнгө	320526.1	341858.1	21332.0
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	196302.8	196302.8	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	320526.1	341858.1	21332.0

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй.

Авлага данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 35750.8 мянган төгрөг болж 12205.8 мянган төгрөгөөр буурсан нь 103766.8 мянган төгрөгөөр бараа материал нэмэгдүүлж тушаалаар 480.0, бусдаар 255.0, худалдан зарцуулснаар 102768.7 мянган төгрөгийн материалыг тус тус зарцуулж ажилласантай холбон үзэж байна.

Тухайн жил төсвийн хөрөнгөөр 74944.4, ЭМГ-аас 3750.1, иргэнээс 1000.0, мал дэвшилтийн орлогоос 1003.0 мянган төгрөг буюу нийт 103766.8 мянган төгрөгийн орлогыг материалын орлогод бүртгэн тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 893716.7 мянган төгрөг болж 43162.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2183.0, хандив тусламжаар 59897.1 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус нэмэгдүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр элэгдлээ бүрэн нөхсөн биохимийн анализатор, эхо аппарат гэсэн үндсэн хөрөнгийг 3200.0 мянган төгрөгөөр дахин үнэлж тайлагнажээ.

Өр төлбөр данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэж хасагдсан хөрөнгөгүй байна.

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 493547.0 мянган төгрөгийн орлого байгаа нь өмнөх оноос 116480.5 мянган төгрөгөөр буюу 23.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хандив тусламжийн бараа, материалын болон үндсэн хөрөнгө нэмэгдүүлсэн дүнгийн өөрчлөлт байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 67013.4 мянган төгрөгөөр буюу 14.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оноос дахин үнэлгээний данс 3200.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт гарч нягтлан бодох бүртгэл, стандартын дагуу бүртгэж тайлагнасан байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 335848.8, ЭМДСангаас 32709.4, орон нутгийн төсвөөс 29435.5 буюу нийт 397993.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулж санхүүжүүлэхээр 397993.7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 335848.8, ЭМДСангаас 30935.5, орон нутгийн төсвөөс 24941.9, нэмэлт санхүүжилтээр 13828.2, нийт 405554.4 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 403523.7 мянган төгрөгийг зарцуулж 2030.7 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 403523.7 мянган төгрөг буюу 99.4 хувьтай зарцуулж батлагдсан санхүүжилтийг бүрэн хэмжээнд зарцуулсан байна.

Улсын/орон нутгийн/төсөвт төвлөрүүлэх орлого

Өөрийн орлогыг төлөвлөөгүй болно.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр 13828.2 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна.

3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1536.9 мянган төгрөгийн зөрчлөөс 256.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж 1280.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг биелүүлсэн байна.

Аудитаар өгсөн 1280.9 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийн 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажилласан тайланг албан тоотын хавсралтаар ирүүлж ажиллажээ.

Нийт 1536.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 256.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1280.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мян/төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	256.0	1	256.0			
Зөвлөмж	2	1280.9	2	1280.9			
Нийт дүн	3	1536.9	3	1536.9			

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12797.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 558.5 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 7394.8 мянган төгрөгийн алдаа зөрчил 1 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4844.6 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч ажиллалаа.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой залруулгын алдаа илрээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7953.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 558.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон, 7394.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Тус байгууллагын шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэлгүй, шатахууны цохолтгүй 477719 төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллагын эмийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад харилцагч байгууллагатай тооцоо нийлж ажиллаагүй “Монос трейд” ХХК-нд шилжүүлэх эмийн 80800 төгрөгийг “Монос булган” ХХК руу илүү шилжүүлсэн гэх боловч авлага өглөгийн тайланд тусгаж ажиллаагүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3.Тус байгууллагын жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийсэн анхан шатны баримттай санхүүгийн тодруулга тайлангийн хөрөнгө, материалын үлдэгдэлтэй тулгахад жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн үлдэгдлээр тайлагнасан, мөн 7394823 төгрөгийн эмийн үлдэгдэлд биет тооллого явуулаагүй зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн

этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд Угаагч, ариутгагчийн орон тоог батлаагүй хэрнээ ажил хавсарсны нэмэгдлийг олгосон байна. тусгаж тайлагнана.”, 70.2.1-д “1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;”, 70.2.2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;”, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.3-т “Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ.”, НБББББ-ийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.2-т “тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар батлагдсан үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийснийг түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тухайн байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого чанаргүй байгаа нь анхаарал татахуйц байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Галч нарт олгох цалин, НДШ-ийн зардлыг будсаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд төсөвлөсөн боловч ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг дутуу төсөвлөснөөс шалтгаалж 771.5 мянган төгрөгийг үндсэн ажилчдын НДШ-ийн зардлаас зарцуулсан, мөн бараа үйлчилгээний бусад зардлын 383.9 мянган төгрөгөөр эм худалдан авч бүлэг хооронд зарцуулсан.

1.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага үүсэх.

1.3 Өгсөн зөвлөмж: Жилийн төсвийг бодитой төлөвлөж төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйл ажиллагаандаа зөвлөмжийг тусган авч төсвийг хуваарьт зардлын дагуу зарцуулна.

2. Дотоод асуудалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Байгууллагын бүтэц орон тоог батлахдаа угаагч, ариутгагчийн орон тоог батлаагүй, ажил хавсарсны нэмэгдлийг олгосон байна.

2.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага нэмэгдэх.

- 2.3 Өгсөн зөвлөмж: Дутагдаж байгаа орон тоог үндсэн цалингийн шатлал хувиар батлуулж ажиллаж
- 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2021 оны бүтэц орон тоог сумын Засаг даргын 01-р сарын 29-ны А/07 тоот захирамжаар албан хаагчдын ажил хавсарч буй орон тоог батлуулсан, цаашид зөвлөмжийг тогтмол хэрэгжүүлж ажиллана.
3. Зардал данстай холбоотой асуудал
- 3.1 Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримттай нь түүвэрлэн шалгахад жолоочийн тооцооны замын хуудсыг 1336.4 төгрөгөөр дутуу хөтөлсөн.
- 3.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй.
- 3.3 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах.
- 3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйл ажиллагаандаа зөвлөмжийг тусган авч жолоочийн тооцооны хуудсыг тухай бүр үнэн зөв хөтөлж тогтмол хянаж ажиллана.
4. Зардал данстай холбоотой асуудал
- 4.1 Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа тендерт шалгарсан компаниас худалдан авалт хийгээгүй, тендерт шалгараагүй компаниас 172.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрлээ.
- 4.2 Эрсдэл: Холбогдох хууль журам зөрчигдөх
- 4.3 Өгсөн зөвлөмж: Тухайн жилд эмийн тендерт шалгарсан компаниас худалдан авалт хийх, мөн ЭМГ-ийн зөвлөмжийг мөрдөж ажиллах.
- 4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйл ажиллагаандаа зөвлөмжийг тусган авч тухайн онд тендерт шалгарсан эм ханган нийлүүлэх байгууллагаас эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хийж зөрчилгүй ажиллана.

Дээрх 4 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дашинчилэн сумын ЭМТ	Аудитын код:
2020			САГ-2021/45/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Харилагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаагүй, илүү шилжүүлсэн эмийн зардлыг авлага, өглөгийн тайланд	80.8	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	М.Соёлмаа, Н.Оюундарь

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	тусгаагүй.				
2	Шатахууны зарцуулалтыг даргын цохолтгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу шатахуун зарцуулсан.	477.7	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	М.Соёлмаа, Н.Оюундарь
3	Байгууллагын жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг явуулахдаа 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлээр тайлагнаж бараа материалыг 11903.8, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг 15100.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнаж, санхүүгийн тодруулга тайланд тайлагнасан, 7394.8 мянган төгрөгийн эмийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна.	7394.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	М.Соёлмаа, Н.Оюундарь
4	Галч нарт олгох цалин, НДШ-ийн зардлыг будсаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд төсөвлөсөн боловч ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг дутуу төсөвлөснөөс шалтгаалж 771500 төгрөгийг үндсэн ажилчдын НДШ-ийн зардлаас зарцуулсан. Мөн бараа үйлчилгээний бусад зардлын 383900 төгрөгийн эм худалдан авахдаа бүлэг хооронд зарцуулах эрх үүсээгээгүй.	1155.4	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	М.Соёлмаа, Н.Оюундарь
5	Угаагч, ариутгагчийн орон тоог батлаагүй хэрнээ ажил хавсарсны нэмэгдлийг олгосон байна.	2180.3	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	М.Соёлмаа, Н.Оюундарь
6	Жолоочийн тооцооны замын хуудсыг дутуу хөтөлсөн.	1336.4	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	М.Соёлмаа, Н.Оюундарь
7	Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа тендерт шалгараагүй компаниас худалдан авалт хийсэн байна.	172.5	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	М.Соёлмаа, Н.Оюундарь
ДҮН		12797.9			

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР
 МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
 АХЛАХ АУДИТОР П.МӨНХТУЯА